

Independent Director Report for the year ended 31st December, 2020

Financial Year ended 301st December 2020 has been a challenging one. The emergence of Covid-19 in the first quarter and its spread worldwide by the end of the second quarter provided a once in a lifetime challenge to the board and management of XacBank (the "Bank").

As an independent director, I considered that I had to pay particular attention to the following areas of a duty of an independent director:

- a. Safeguard the interests of all stakeholders: customers, employees, and shareholders; and
- b. Ascertain that the Bank has a robust risk management system due to the uncertain environment resulting from the Covid-19 pandemic.

Accordingly I kept myself informed of the business of the bank, the situation in Mongolia and the challenges management faced. I provided guidance and opinion whenever needed. This was facilitated by the attending regular meetings via teleconferencing facilities.

In my opinion, the management of XacBank, with the support of the Board, did an excellent job in ensuring:

- a. the health safety of the Bank's employees and customers; and
- b. took the necessary actions to ensure that the bank remains highly liquid and solid capital adequacy position.

As a member of the Risk Committee, during its regular meetings, we paid particular attention to potential risks arising out of the unusual situation created by the Covid-19.

The Audit Committee ensured that the Bank followed the central bank guidelines regarding the loan portfolio of the Bank, acknowledging at the same time the need for the Bank to show flexibility to support deserving customers.

The Audit Committee monitored the work of the Internal Audit department, whose work was challenging at times given due to travel restrictions due to Covid-19. The Internal Audit Department was able to complete its 2020 work as planned.

The Audit Committee reviewed and approved the Internal Department Budget and Audit Plan for the Financial year 2021.

The Audit Committee worked with the external auditors on accounting matters related to Covid-19. To that effect the Audit Committee had a virtual meeting with the external auditors for a half yearly review based on the financial statements for the 6 month ended 30th June 2020.

Regarding the strategy of the Bank, there was, via board meetings and monthly review meetings, the ongoing monitoring of the successful execution of the strategy consisting of improving the liability management, asset reduction and cost reduction. The result is a more efficient and profitable bank with a solid capital base.

Finally in my opinion, the board has fully accomplished its duties. Under the enlightened and insightful leadership of the Chairman, members of the board were able to freely and respectfully expressed their opinions and make decisions which were in the best interest of the bank, its customers, employees and shareholders.


Signed by



Lim Sit Chen Lam Pak Ng

27th January, 2021

YXH4937 2578697



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүний тайлан
(2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

2020 оны 12 дугаар сарын 31-нд дууссан санхүүгийн жил хүндрэл бэрхшээлтэй жил болж өнгөрлөө. 2020 оны эхний улиралд Ковид-19 өвчний халдвар анх гарч, хоёрдугаар улирлын эцсээр дэлхий даяар тархсан цар тахал болсон нөхцөл байдал нь ХасБанкны гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн хувьд асар их шийдвэрлэх асуудлуудыг бий болгосон.

Хараат бус гишүүний хувьд дараах асуудлуудад онцгой анхаарал хандуулан ажиллав.

- a. Банкны харилцагчид, ажиллагсад, хувьцаа эзэмшигчид болон бусад бүх нэгдмэл сонирхолтой холбогдох талуудын ашиг сонирхолыг хамгаалах,
- b. Ковид-19 цар тахлын улмаас үүссэн тодорхой бус нөхцөл байдалд эрсдэлийн удирдлагын сайн тогтолцоо байгаа эсэхийг баталгаажуулах.

Тайлант хугацаанд Монголын нөхцөл байдал, Банкны бизнес, гүйцэтгэх удирдлагын тулгарч буй асуудлуудыг харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан ТУЗ-ийн ээлжит хурал болон бусад шаардлагатай үед хэлэлцэж, санал өгч, удирдамжаар хангаж ажилласан.

Банкны гүйцэтгэх удирдлага Банкны ТУЗ-ийн дэмжлэгтэйгээр дараах асуудлуудыг шийдвэрлэж сайн ажилласан гэж дүгнэж байна.

- a. Банкны харилцагч, ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажилласан,
- b. Банкны зохистой харьцаанууд /төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ/-ыг хангах талаар шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилласан.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажиллаж, хорооны ээлжит хурлуудаар Ковид-19 цар тахлын улмаас бий болсон ер бусын нөхцөл байдал, түүнээс үүдэлтэйгээр гарч болзошгүй эрсдэлүүдийг хэлэлцэж онцгой анхаарал хандуулж ажилласан.

ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүний хувьд зээлийн багцын талаар Монголбанкнаас гарсан удирдамжийг даган мөрдөхийн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд харилцагчидад дэмжлэг үзүүлэх асуудалд Банкны зүгээс уян хатан хандах явдалд анхаарал хандуулж ажилласан.

Тайлант хугацаанд Ковид-19 цар тахлын улмаас хил хаагдсантай холбогдон Банкны Дотоод Аудитын Газрын үйл ажиллагаанд хүндрэлтэй асуудлууд гарч байсан бөгөөд ТУЗ-ийн Аудитын хорооноос хяналт тавьж ажилласаны үр дүнд Дотоод Аудитын Газрын 2020 оны төлөвлөгөөнд тусгасан бүх ажлуудыг хийж гүйцэтгэж дууссан.

ТУЗ-ийн Аудитын Хороо Банкны Дотоод Аудитын Газрын 2021 оны санхүүгийн жилийн төсөв, аудитын төлөвлөгөөг хэлэлцэж баталсан.

ТУЗ-ийн Аудитын Хороо нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, хөл хорионоос үүсэн гарч буй нягтлан бодох бүртгэлийн асуудлаар дээр хөндлөнгийн аудиторуудтай хамтран ажилласан. 2020 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан санхүүгийн тайлан тэнцлийг хөндлөнгийн аудитаар хянуулах явцад ТУЗ-ийн Аудитын Хороо нь хөндлөнгийн аудиторуудтай цахим уулзалтуудыг зохион байгуулж ажилласан.

Банкны стратегийн хувьд актив, пассивын удирдлага, актив ба зардлыг бууруулах дээр баримтлах стратегийг амжилттай хэрэгжүүлж буй эсэх асуудлыг ТУЗ-ийн ээлжит хурал болон сар бүр явуулж буй хэлэлцүүлгээр дамжуулан байнга хянаж, мониторинг хийж ирсэн. Ингэсний үр дүнд Банкны өөрийн хөрөнгө хүрэлцээтэй, үйл ажиллагаа нь илүү үр дүнтэй байна.

Тайлант хугацаанд Банкны ТУЗ нь үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлж гүйцэтгэсэн гэж дүгнэж байна. ТУЗ-ийн даргын гярхай, гэгээрүүлсэн удирдлага дор ТУЗ-ийн гишүүд санал бодлоо чөлөөтэй, бие биенээ хүндэтгэсэн байдлаар солилцож, Банкны харилцагчид, ажиллагсад, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолын төлөө шийдвэр гаргаж ажиллаж чадсан.

Тайлан бичиж, гарын үсэг зурсан

Лим Сит Чен Лам Пак Нг

Огноо: 2021 оны 1-р сарын 27